



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 07 сарын 17 өдөр

Дугаар А/437

Эрдэнэт

Хөрөнгө зарцуулах зөвшөөрөл
олгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийн дуудлагын худалдааг зохион байгуулах журам”-ын 3.6 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн өмчит байгууллагуудад ашиглаж байсан хуучин автомашинуудыг дуудлага худалдаагаар худалдах ажлыг зохион байгуулахад гарсан буюу цаашид гарах зардалд шаардагдах 577500 /Таван зуун далан долоон мянга таван зуун/ төгрөгийг хавсралтаар баталсугай.

2.Дээрх зардлыг дуудлагын худалдааны орлогоос гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.



ЗАСАГ ДАРГА

Д.БАТЛУТ



ДУУДЛАГЫН ХУДАЛДАА ЗОХИОН БАЙГУУЛАХАД
ШААРДЛАГАТАЙ ЗАРДАЛ

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Үнэлгээний ажлын хөлс	удаа	1	360,000	360,000
2	A4 бичгийн цаас	боодол	5	8,500	42,500
3	Принтерийн хор	ширхэг	1	75,000	75,000
4	Зар мэдээллийн үнэ	удаа	1	100,000	100,000
	Дүн				577,500